



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 448

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 43.4 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн нэгдсэн санд даатгуулагчийн болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээллийг цахимаар хүргүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, эрүүл мэндийн даатгалын мэдээллийг цахимаар хүргүүлж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Л.Бямбасүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

3. Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, сэргээн засах, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, дүүргийн Засаг дарга наарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхэзүл), аймаг, нийслэлийн Засаг дарга наарт, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг наарт тус тус үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 67 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


6. Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА



ИИТА1283 0920101894 5483449

Засгийн газрын 2023 оны 12 дугаар
сарын 18 -ны өдрийн 448 дугаар
тогоолын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

ИТА1206 9023100394 5498449

1.1. Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлан тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх хяналт тавих, оролцогч талуудын үйл ажиллагаа, эрх, үүргийг тодорхойлох, цагийн хөлс, урамшуулал олгох, мэдээллийн сан бурдуулэх, ашиглах, маргааныг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг энэ дүрмээр зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл (цаашид “Магадлалын төв зөвлөл” гэх) нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд, Эрүүл мэндийн магадлалын зөвлөл (цаашид “аймаг, дүүргийн магадлалын зөвлөл” гэх) нь аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэд тус тус ажиллана.

1.3. Магадлалын төв зөвлөлийн дэргэд орон тооны бус Сэтгэцийн өвчний салбар зөвлөл, Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөл (цаашид “салбар зөвлөл” гэх) тус тус ажиллана.

1.4. Сэтгэцийн өвчний салбар зөвлөл нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв байгууллагыг, Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөл нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийг тус тус түшиглэн ажиллана.

1.5. Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын хууль тогтоомж, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг мөрдөнө.

1.6. Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

1.7. Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл эрх, үүргийн хүрээнд шийдвэр гаргах ба энэ нь акт, албан шаардлага, шийдвэр, дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байна.

1.8. Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг нийгмийн даатгалын байгууллагын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

Хоёр.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүн, тавигдах шаардлага, томилж, чөлөөлөх

2.1.Төв зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, нийгмийн даатгалын байгууллагын магадлагч эмч 10, мэдээллийн технологийн мэргэжилтэн 1, шинжээч эмч 6, даатгуулагч, ажил олгогчийн төлөөлөл тус бүр 1, нийт 21 хүний бүрэлдэхүүнтэй байна. Төв зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч, мэдээллийн технологийн мэргэжилтэн орон тооны байна.

2.2.Төв зөвлөлийн бүрэлдэхүүнийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга доор дурдсан байдлаар томилж, чөлөөлнө:

2.2.1.дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч, мэдээллийн технологийн мэргэжилтнийг холбогдох хууль тогтоомжийг үндэслэн;

2.2.2.орон тооны бус шинжээч эмчийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцэн;

2.2.3.даатгуулагч болон ажил олгогчийн төлөөллийг Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, ажил олгогчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагын саналыг үндэслэн.

2.3.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн гишүүнийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

2.4.Сэтгэцийн өвчний салбар зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэшлийн эмч 4, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл тус бүр 1, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.5.Сэтгэцийн өвчний салбар зөвлөлийн дарга нь Төв зөвлөлийн нарийн бичгийн дарга, эсхүл магадлагч эмч, орлогч дарга нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв байгууллагын ерөнхий захирал, нарийн бичгийн дарга нь Сэтгэцийн эрүүл мэндийн төв байгууллагын эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан, нийгмийн халамжийн байгууллагын төлөөлөл нь нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан мэргэжилтэн, хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагын төлөөлөл тус тус байна.

2.6.Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, төрөлжсөн мэргэшлийн эмч 4, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл болон хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл тус бүр 1, нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.7.Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөлийн дарга нь Төв зөвлөлийн нарийн бичгийн дарга, эсхүл магадлагч эмч, орлогч дарга нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагын Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дарга, нарийн бичгийн дарга нь Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын

төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан тус тус байна.

2.8. Салбар зөвлөлийн гишүүнийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга доор дурдсан байдлаар томилж, чөлөөлнө:

2.8.1. үйлдвэрчний эвлэлийн төлөөллийг Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос, ажил олгогчийн төлөөллийг Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос нэр дэвшүүлсэн саналыг тус тус үндэслэн;

2.8.2. хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөллийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагын саналыг үндэслэн;

2.8.3. төрөлжсөн мэргэжлийн эмчийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв байгууллагын болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагын саналыг үндэслэн, Төв зөвлөлийн даргатай зөвшилцөн.

2.8.4. нийгмийн халамжийн байгууллагын төлөөллийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн.

2.9. Аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч тус бүр 1, төрөлжсөн мэргэшлийн эмч 3, нийгмийн халамжийн байгууллага, үйлдвэрчний эвлэлийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөлөл тус бүр 1, нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.10. Аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн дарга нь аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга, орлогч дарга нь аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ эрхэлсэн орлогч дарга тус тус байна.

2.11. Аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн нарийн бичгийн дарга нь аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн ажилтан, магадлагч эмч нь аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын магадлагч эмч, нийгмийн халамжийн байгууллагын төлөөлөл нь аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (хэлтэс)-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан мэргэжилтэн тус тус байна.

2.12. Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга нь доор дурдсан байдлаар зөвлөлийн бүрэлдэхүүний саналыг холбогдох байгууллагаас авч, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Үүнд:

2.12.1. аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газартай зөвшилцөн ирүүлсэн саналыг;

2.12.2. аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөллийг аймаг, дүүргийн Засаг дарга тухайн орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах зорилгоор тэдний харьяалагдах төрийн бус байгууллагын саналыг авч, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөлөөр хэлэлцүүлсний үндсэн дээр ирүүлсэн саналыг;

2.13.Аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн үйлдвэрчний эвлэлийн төлөөллийг томилуулахдаа Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос нэр дэвшүүлсэн саналыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.14.Шинжээч эмч, төрөлжсөн мэргэшлийн эмчийг 3 жилийн хугацаагаар томилох бөгөөд ажлын үр дүн, туршлагыг нь харгалзан үзэж хугацааг 1 удаа 3 жилийн хугацаагаар улирааж болно.

2.15.Шинжээч эмч, төрөлжсөн мэргэшлийн эмч нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна:

2.15.1.мэргэжил (мэргэшил)-ээрээ 3-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй их эмч;

2.15.2.ял шийтгүүлж байгаагүй;

2.15.3.мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй;

2.15.4.ашиг сонирхлын зөрчилгүй, багаар ажиллах чадвартай;

2.15.5.нийтийн эрх ашиг, шударга ёсыг дээдэлдэг, ажлын хамт олондоо нэр хүндтэй байх.

2.16.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагын хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч, хүн тэдгээрийн онцлог хэрэгцээ, эрхийн чиглэлээр зохих сургалтад хамрагдсан байна.

2.17.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүн нь нийтийн эрх ашиг, шударга ёсыг дээдэлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, харилцан бие биеэ хүндэтгэж, үндэслэл бүхий шийдвэр гаргана.

Гурав.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл
ажиллагааны төрөл, хэлбэр, дэг

3.1.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаа нь хурал хэлбэртэй байх ба даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг дараах хэлбэрээр шийдвэрлэнэ:

3.1.1.даатгуулагч, хүнийг байлцуулахгүйгээр холбогдох баримт бичигт үндэслэн;

3.1.2.цахим хэлбэрээр.

3.2.Энэ дүрмийн 3.1.1-д заасан хэлбэрээр шийдвэрлэх тохиолдолд даатгуулагч, хүнийг биечлэн ирүүлэхгүйгээр холбогдох баримт бичигт үндэслэн оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээний үр дүн, эрүүл мэндийн байдал, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг магадлна.

3.3. Энэ дүрмийн 3.1.2-т заасан хэлбэрээр шийдвэрлэх тохиолдолд даатгуулагч, хүнийг биечлэн ирүүлэхгүйгээр мэдээлэл, технологийн шийдлийг ашиглан зайн үзлэг хийж, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, сэргээн засах тусlamж үйлчилгээний үр дүн, эрүүл мэндийн байдал, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг магадална.

3.4. Энэ дүрмийн 3.1.1, 3.1.2-т заасан хэлбэрээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг шийдвэрлэх боломжгүй болон даатгуулагч, хүн өөрөө хүссэн тохиолдолд биеэр байлцуулан магадалж болно.

3.5. Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх, ажлын цаг богиносгох асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баталсан өвчний жагсаалтыг баримтлан шийдвэрлэнэ.

3.6. Салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь 7 хоногт 1 удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд 1-ээс дээш удаа хуралдаж шийдвэрийг олонхын саналаар гаргана.

3.7. Дараах тохиолдолд магадлалын зөвлөлийн хурлыг хойшлуулж хуралдсан тохиолдолд хүчингүйд тооцно:

3.7.1. төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн нийт гишүүдийн ирц гуравны хоёрт хүрээгүй тохиолдолд;

3.7.2. төв зөвлөлийн хуралд дарга, нарийн бичгийн дарга, салбар, зөвлөлийн хуралд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга нэгэн зэрэг оролцоогүй тохиолдолд;

3.7.3. аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хуралд дарга, магадлагч эмч, нарийн бичгийн дарга нэгэн зэрэг оролцоогүй тохиолдолд.

3.8. төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн дарга, тухайн өдрийн хуралд оролцоогүй тохиолдолд, орлогч дарга тухайн хурлыг даргалан зөвлөлийн хурлыг удирдан явуулна.

3.9. Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн дарга, орлогч дарга, гишүүд тус бүр саналын эрхтэй байх бөгөөд Төв зөвлөл болон Сэтгэцийн өвчний салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга саналын эрхтэй байна.

3.10. Салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг хэлэлцэн шийдвэрлэхэд тухайн зөвлөлийн нарийн бичгийн даргын гаргасан хурлын дарааллыг баримтална.

3.11. Төрөлжсөн мэргэшлийн болон хяналтын эмч нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих талаар мэдээллийг магадлалын зөвлөл хуралдахаас 1-5 хоногийн өмнө салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлд цахимаар хүргүүлнэ.

3.12.Салбар болон орон нутгийн комисс даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих асуудлыг ажлын 5 хүртэл хоногт багтаан шийдвэрлэнэ.

3.13.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлөөс даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн актыг эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн тусгай программаар үйлдэх ба актад хуралд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

**Дөрөв.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг
шийдвэрлэх үйл ажиллагаа**

4.1.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгох, сунгуулах, цуцуулах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих асуудлыг шийдвэрлүүлэхдээ төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчид хүсэлтээ гаргах ба төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмч холбогдох баримт бичиг, оношийг баталгаажуулах шинжилгээ, оношилгоог бүрдүүлж, үечилсэн дүгнэлт, саналыг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хуралд танилцуулна.

4.2.Даатгуулагч, хүн нь ердийн өвчин болон ахуйн осол, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд 66-132 өдрөөс хэтрэхгүй хугацаатай эмчийн хяналтад эмчлүүлэх бөгөөд эмчилгээний үр дүн, өвчний явц, үе шат, хүндрэлийн талаарх баталгаажсан оношилгоо, шинжилгээний үр дүнд үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгох эсэх асуудлыг шийдвэрлүүлнэ.

4.3.Даатгуулагч, хүний эрхтэн, бие махбодийн тогтоц, үйл ажиллагаа нь эргэшгүй өөрчлөлтөд орж, хүндээр гэмтсэний улмаас өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй, бусдын асаргаа сувилгаа шаардлагатай болсон, байнгын хэвтэрт байгаа тохиолдол болон хорт хавдар өвчний III, IV үед энэ дурмийн 4.2-т заасан хугацааг болон эмнэлгийн хуудас авсан, эмчийн хяналтад орсон, эмчлүүлсэн эсэхийг нь үл харгалзан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоож болно.

4.4.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгааныг ердийн өвчин, ахуйн осол болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас гэж тус тус ангилаа.

4.5.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг доор дурдсанаар ангилаа:

4.5.1.бүрэн буюу 70 ба түүнээс дээш хувиар алдсан;

4.5.2.хагас (хэсэгчлэн) буюу 70 хүртэл хувиар алдсан.

4.6.Салбар, аймаг, дүүрэг, сумын магадлалын зөвлөл даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөхдөө оношилгоо, шинжилгээ, төрөлжсөн мэргэшлийн болон хяналтын эмчийн дүгнэлт, саналыг үндэслэх ба үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт, саналыг тус тус үндэслэнэ.

4.7.Хүн амын тоо, нягтрал, байршил зэргийг харгалзан сумын нийгмийн даатгалын тасгийн дэргэд сумын Эрүүл мэндийн магадлалын зөвлөлтэй тохиолдолд даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг сумын эрүүл мэндийн төвийн хяналтын эмч хариуцан шийдвэрлүүлнэ.

4.8.Гадаад улсад хорт хавдар, сүрьеэ, эрхтэн шилжүүлэх болон бусад өвчиний шалтгаанаар 132 хоногоос дээш хугацаагаар эмчлүүлж байгаа даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг шийдвэрлэхдээ үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдсан, эмчлүүлж байгаа талаарх тухайн улсын эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, биеийн эрүүл мэндийн байдлын талаарх дүгнэлтийн эх хувь болон тухайн улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яам, эсхүл Консулын газрын тодорхойлолт, итгэмжлэл, хүний хувийн хүсэлтэд үндэслэн салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.9.Энэ дүрмийн 4.7, 4.8-д заасан даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг мөн дүрмийн 3.1.1, 3.1.2-т заасан хэлбэрээр хуралдан шийдвэрлэнэ.

4.10.Шүүхээр ял эдэлж буй ялтанд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг зөвхөн хорихын нэгдсэн эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн эмчийн дүгнэлт, саналыг үндэслэн хорих байгууллагын харьялах аймаг, дүүргийн магадлалын зөвлөл, эсхүл салбар зөвлөл шийдвэрлэнэ.

4.11.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг тогтоох үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна:

4.11.1.ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн ослын шалтгаантай хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоолгох даатгуулагч, хүний өвчиний түүх, оношилгоо, шинжилгээний өөрчлөлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдээлэл, хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэсэн үндсэн болон хавсарсан өвчиний онош, өвчиний үе шат, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа зэргийг тусгасан дүгнэлт, санал, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн актыг бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төрөлжсөн мэргэшлийн болон хяналтын эмч нь аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хуралд танилцуулна;

4.11.2.нийслэлийн дүүрэгт оршин сууж буй сэтгэцийн өвчиний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоолгох даатгуулагч, хүний өвчиний түүх, оношилгоо, шинжилгээний өөрчлөлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдээлэл, хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэсэн үндсэн болон хавсарсан өвчиний онош, үе шат, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа зэргийг тусгасан үечилсэн дүгнэлт, саналыг төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмч нь сэтгэцийн өвчиний салбар зөвлөлийн хуралд танилцуулна;

4.11.3.мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын шалтгаантай хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоолгох даатгуулагч, хүний өвчиний түүх, оношилгоо, шинжилгээний өөрчлөлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх

Мэдээлэл, хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэсэн үндсэн болон хавсарсан өвчний онош, өвчний үе шат, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа зэргийг тусгасан үучилсэн дүгнэлт, санал (мэргэжлээс шалтгаалсан өвчний үед хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт, хөдөлмөрийн нөхцөлийн тодорхойлолт)-ыг Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмч, мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөлийн хуралд танилцуулна;

4.11.4.салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь даатгуулагч, хүний биеийн эрүүл мэндийн байдал, шинжилгээ, оношилгооны өөрчлөлт, өвчний үе шат, хүндрэл, дэлгэрэнгүй онош, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг тусгасан төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчийн дүгнэлт, саналыг үндэслэн хувь, хугацаа, шалтгааныг тогтооно;

4.11.5.салбар, орон нутгийн комисс нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох асуудлыг дахин магадлах шаардлагатай гэж үзвэл холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлж, үзлэг оношилгоог давтан хийсний үндсэн дээр шийдвэрлэнэ;

4.11.6.салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах үндэслэлгүй гэж үзвэл шийдвэр гаргахгүйгээр үндэслэл бүхий хариу өгнө;

4.11.7.хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг шинээр тогтооход салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн өдрөөс эхлэн тооцох ба хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд энэ хугацаа хамаарахгүй;

4.11.8.хоёр буюу түүнээс дээш тооны өвчнөөр өвчилсөн даатгуулагч, хүний үндсэн өвчнийг сонгон хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг тогтоож, хавсарсан өвчний үе шат, явц, биеийн ерөнхий байдал зэргийг харгалзан хөдөлмөрийн чадвар алдалтыг тав хүртэл хувиар нэмж тогтоож болох ба үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдолд даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг тооцоход ердийн өвчний хувийг нэмж тооцохгүй.

4.12.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг сунгах, цуцлах үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна:

4.12.1.даатгуулагч, хүн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг сунгуулахдаа өмнөх шийдвэрийн хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө, эсхүл уг хугацаа дууссанаас хойш 14 хоногийн дотор магадлалын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн тохиолдолд өмнөх шийдвэрийн хугацаа дууссанаас хойш үргэлжлүүлэн сунгана. Харин энэ хугацаа өнгөрсөн тохиолдолд хурлаар хэлэлцсэн өдрөөс эхлэн сунгаж шийдвэрлэнэ;

4.12.2.даатгуулагч, хүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ дүрмийн 4.12.1-д заасан хугацаанаас хойш 6 сарын дотор сунгуулах хүсэлт гаргасан бол хүндэтгэн үзэх шалтгааныг нотлох баримтад үндэслэн салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн өдрөөс эхлэн тооцож, ердийн

өвчин бол 2 сараас, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчин бол 6 сараас илүүгүй хугацаагаар тус тус нөхөн сунгаж болно;

4.12.3.даатгуулагч, хүн өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд хөдөлмөрийн чадвар алдалт тогтоосон хувь, хугацаа хүчинтэй үед өвчний хүндрэл, үе шатыг харгалзан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг дахин магадлан өөрчилж, цуцалж болно;

4.12.4.даатгуулагч, хүн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг шийдвэрлэсэн хугацаа дууссанаас хойш 6 сарын дотор магадлуулаагүй тохиолдолд даатгуулагч, хүнд, эсхүл түүний асран хамгаалагчид мэдэгдэж, хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцлах шийдвэр гаргана.

4.13.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл хөдөлмөрийн чадвар алдалтыг хугацаагүй тогтоолгосон даатгуулагч, хүний эрүүл мэндийн байдал, түүнд үзүүлж байгаа тусlamж, үйлчилгээний талаарх судалгааг хагас, бүтэн жилээр харьяалагдах өрх болон сумын эмчээс авч, хяналт тавьж ажиллана.

4.14.Даатгуулагч, хүний биеийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан хөдөлмөрийн чадвар алдалт, бууралт нь цаашид даамжрах төлөвтэй, дадаж мэргэшсэн ажлаа хөдөлмөрийн тогтоосон цагт тоо, чанарын хувьд бүрэн хийж чадахгүйд хүрсэн бол тухайн даатгуулагч, хүнийг сувицуулах, эмчлүүлэхэд зориулж ажлын цагийг тодорхой хугацаагаар богиносгох шийдвэрийг салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл даатгуулагч, хүний хүсэлтийг үндэслэн гаргана.

4.15.Даатгуулагч, хүний ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх асуудлыг энэ дүрмийн 3.5-д заасан эрх бүхий байгууллагаас баталсан өвчний жагсаалтыг үндэслэн салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл шийдвэрлэнэ.

Тав.Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд
оролцогч талуудын нийтлэг эрх, үүрэг

5.1.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл болон эрүүл мэндийн байгууллага, оролцогч талууд нь дараах нийтлэг эрхтэй байна:

5.1.1.төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн шийдвэрийг алдаагүй, үндэслэлтэй гаргах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн эмч, мэргэжилтнийг татан оролцуулах;

5.1.2.эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд алдаа, дутагдал гаргасан, төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, албан хаагчдад хариуцлага хүлээлгэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэл хүргүүлж, шийдвэрлүүлэх;

5.1.3.аливаа алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн санг эрсдэлээс хамгаалах чиглэлээр үр дүнтэй ажилласан ажилтныг урамшуулах;

5.1.4.даатгуулагч, хүнийг нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээнд хамруулах саналыг хүргүүлэх.

5.2.Хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцогч талууд болох төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл болон эрүүл мэндийн байгууллага, даатгуулагч, хүн нь дараах нийтлэг үүрэгтэй байна:

5.2.1.даатгуулагч, хүн нь өөрийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгох, сунгуулах, цуцлуулах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлүүлэх асуудлыг магадлан шийдвэрлэхэд шаардлагатай эрүүл мэндтэй холбоотой баримт бичиг, шинжилгээ, оношилгооны дүн, дүгнэлт, холбогдох лавлагаа зэрэг мэдээллийг үнэн зөвөөр бүрдүүлж төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчид хүлээлгэн өгөх;

5.2.2.төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмч нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгох, сунгуулах, цуцлуулах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг магадлан шийдвэрлэхэд эрүүл мэндтэй холбоотой баримт бичиг, шинжилгээ, оношилгооны дүн, дүгнэлт, холбогдох лавлагаа зэрэг шаардлагатай мэдээллийг бүрэн бүрдүүлэх, тэдгээрийн үндэслэлийг нягталж, үнэн зөв байдлыг хариуцах;

5.2.3.эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналтавих;

5.2.4.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс анgid байж, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг даатгуулагч, хүнд шударга, чанартай, түргэн шуурхай, чирэгдэлгүй, тэгш хүртээмжтэй үзүүлэх, үнэн зөв мэдээллээр хангах;

5.2.5.даатгуулагч, хүнийг хөдөлмөрийн чадвар алдахаас урьдчилан сэргийлэх, сэргээн засах үйл ажиллагааг дэмжих, энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

5.2.6.даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хагас (хэсэгчлэн) алдсан хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох шийдвэр гаргах;

5.2.7.даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, шинжилгээ, шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгах;

5.2.8.төрийн албаны болон нийгмийн даатгалын хууль тогтоомж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж ажиллах;

5.2.9.эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, тусламж, үйлчилгээг сайжруулах талаар арга хэмжээ авах, санал боловсруулж шийдвэрлүүлэх;

5.2.10.албан үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн болон үүсэж болзошгүй тохиолдолд зохих журмын дагуу мэдэгдэл, тайлбар гаргах бөгөөд Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөж ажиллах.

Зургаа.Төв зөвлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.1. Төв зөвлөл нь салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх үндсэн чиг үүрэгтэй бөгөөд дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана:

6.1.1.эрүүл мэндийн магадлалтай холбоотой маргааныг шинжээч эмчийн болон эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн дүгнэлт, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын үзлэг, оношилгоо, шинжилгээний дүнг үндэслэн гомдол гаргагч даатгуулагч, хүнийг биеэр байлцуулан шийдвэрлэх ба гаргасан шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно;

6.1.2.салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, давтан сургах, сургалтад хамруулах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

6.1.3.салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, гаргасан шийдвэр нь хууль тогтоомжид нийцээгүй бол өөрчлөх, цуцлах арга хэмжээ авч, илэрсэн зөрчлийг арилгуулах, буруутай этгээдэд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцох, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаарх саналыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бусад холбогдох байгууллагад хүргүүлэх;

6.1.4.аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаанд асуудал хариуцсан төлөвлөлтийг сайжруулах, хөдөлмөрийн чадвар алдалтын талаар тооцоо, судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, тогтмол сайжруулах, ашиглах, хууль тогтоомжийн хүрээнд харилцан мэдээлэл солилцох чиглэлээр зохих арга хэмжээ авах;

6.1.5.эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийн зардлын төсвийн төслийг нарийвчилсан хуваарийн саналын хамт хуульд заасан хугацаанд боловсруулж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

6.1.6.мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын үйл ажиллагаа, үр дүн, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

6.1.7.энэ дүрмийн 7.1.8-д заасны дагуу салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлөөс ирүүлсэн тайлан, мэдээг улсын хэмжээнд хагас, бүтэн жилээр нэгтгэн дүгнэж, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллага, бусад мэргэжлийн байгууллагатай хамtran хяналт шалгалт хийх;

6.1.8.энэ дүрмийн 6.1.7-д заасан тайланда хөдөлмөрийн чадвар алдалтын байдлыг улсын хэмжээнд, аймаг, дүүрэг, сум, хороо, тосгоноор ангилан өвчний

оношоор бүлэглэж, хүн амд харьцуулсан судалгааг боловсруулан тусгаж, дүгнэлт гаргах.

6.2.Төв зөвлөл нь шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагын байр, багаж хэрэгсэл, лаборатори, эм, урвалжийг оношилгоо, магадалгаа хийх зорилгоор үнэ төлбөргүй ашиглаж болно.

6.3.Төв зөвлөл нь эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журмын талаар болон зөвлөлийн үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулан ажиллана.

6.4.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг бууруулах, цуцалсантай холбоотой даатгуулагч, хүний гаргасан гомдлыг 6 сар ба түүнээс дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд төв зөвлөл хүлээн авч шийдвэрлэхгүй ба эмчилгээ, оношилгоо хийлгэсний дараа дахин хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох эсэх асуудлыг салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл шийдвэрлэнэ.

6.5.Төв зөвлөлийн хамтарсан болон дахин магадлал, эрх бүхий байгууллагын хяналт шалгалтад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хамрагдаагүй бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг түр түдгэлзүүлж, холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд цуцлах арга хэмжээ авч ажиллана.

**Долоо.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн
хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

7.1.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана:

7.1.1.даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвараа алдсан хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх асуудлыг төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчийн дүгнэлт, саналыг үндэслэн тогтоох;

7.1.2.эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын үзлэг, оношилгоо, шинжилгээний дүнг үндэслэн эрүүл мэндийн магадлал хийх;

7.1.3.хөдөлмөрийн нөхцөл нь биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж, өвчин эмгэг нь даамжран, цаашид хүндрэх төлөвтэй даатгуулагч, хүний хөдөлмөрийн нөхцөлийг эхний удаа 6 сар хүртэл хугацаагаар өөрчлөх, шаардлагатай тохиолдолд хөдөлмөрийн нөхцөлийг хугацаагүйгээр өөрчлөх шийдвэр гаргах;

7.1.4.биеийн эрүүл мэндийн байдлын улмаас хөдөлмөрийн чадварын бууралт нь цаашид даамжрах төлөвтэй, тогтоосон хөдөлмөрийн цагт бүрэн хөдөлмөрлөх боломжгүй болсон даатгуулагч, хүний ажлын цагийг богиносгох шийдвэр гаргах;

7.1.5.тухайн аймаг, дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын мэдээллийн цахим санг тогтмол хөтөлж, бүрдүүлэх, шинэчлэх арга хэмжээ авч

мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангаж ажиллах, хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, дүгнэлт хийх;

7.1.6.тухайн аймаг, дүүргийн иргэний бүртгэлийн байгууллагатай хамтран хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн шилжилт хөдөлгөөн, нас баралтын мэдээллийг сар бүр тулгах, нягтлах, холбогдох өөрчлөлтийг мэдээллийн санд тогтмол оруулах;

7.1.7.салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах;

7.1.8.үйл ажиллагааны хагас жилийн тайлан, мэдээг жил бүрийн 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайлан, мэдээг дараа жилийн 01 дүгээр сарын 10-ны өдөр дотор багтаан Магадлалын төв зөвлөлд хүргүүлж, тайлан, мэдээний үнэн зөвийг хариуцах;

7.1.9.үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалтын төсвийг хуульд заасан хугацаанд боловсруулан магадлалын төв зөвлөлд хүргүүлэх;

7.1.10.үйлдвэрлэлийн осол, хурц хордлого болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч, хүнд үзүүлж буй мэргэжлээс шалтгаалсан өвчний сувилах, сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавих;

7.1.11.даатгуулагч, хүний гаргасан өргөдөл гомдлыг холбогдох хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариу өгч ажиллах;

7.1.12.магадлалын төв зөвлөлөөс өгсөн хууль тогтоомжид нийцсэн үүрэг, даалгаврыг шуурхай биелүүлэх;

7.1.13.хуурамч баримт бичиг бүрдүүлсэн даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах асуудлыг шийдвэрлэхгүй бөгөөд хуурамч баримт бичиг бүрдүүлэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгосон шийдвэрийг цуцалж, буруутай этгээдээр хохирлыг барагдуулах арга хэмжээ авах;

7.1.14.хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч, хүн, түүний гэр бүлд эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний талаар мэдээлэл, сургалт сурталчилгаа, зөвлөгөө зөвлөмж өгч ажиллах.

7.2.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл нь энэ дүрмийн 7.1-д зааснаас гадна хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч, хүний эрх ашиг зөрчигдэж байгаа эсэхэд хяналт тавьж, холбогдох төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах орон тооны бус зөвлөлд мэдээлэх, тайлагнах, төрийн байгууллагын болон иргэдийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр идэвх санаачилга гарган ажиллах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.3.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн нийгмийн халамжийн байгууллагын төлөөлөл нь энэ дүрмийн 7.1-д зааснаас гадна даатгуулагч, хүнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэг туслалцаа

Үзүүлэх үйл ажиллагаанд хамруулах талаар зөвлөлгөө өгөх, сургалт сурталчилгаа хийх, ажилд зуучлах, хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.4.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь эрүүл мэндийн байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх, мэдээлэл хүргэх явуулын цахим зарын самбар (узель, микрофон, электрон урсдаг дэлгэц, зурагт, бусад) ашиглаж эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагааг нийтэд сурталчлах, мэдээллийг нээлттэй, ил тод хүргэх арга хэмжээг зохион байгуулан ажиллана.

7.5.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн гишүүд нь мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагаа харилцан солилцож, орчны болон мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийг хангах, бусад асуудлаар хамтарч ажиллана.

7.6.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн гишүүн 30 хоногоос дээш хугацаагаар хүндэтгэх шалтгааны улмаас чөлөө авах тохиолдолд энэ тухайгаа 1 сарын өмнө тухайн зөвлөлийн дарга, магадлалын төв зөвлөлд урьдчилан мэдэгдэнэ.

7.7.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл эрүүл мэндийн магадлал хийх үед эргэлзээтэй, мэргэжил, арга зүйн зөвлөгөө шаардлагатай асуудал гарсан тохиолдолд магадлалын төв зөвлөлд хандан мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч болно.

7.8.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл холбогдох хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр холбогдох баримт бичгээ ирүүлээгүй, тухайн магадлалын зөвлөлийн болон эмчлэгч эмчийн эмчилгээ, үйлчилгээний зөвлөмж, зааврыг удаа дараа биелүүлээгүй, нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдаагүй, эмчийн хяналтад ороогүй даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгахаас татгалзах, цуцлах шийдвэр гаргана.

7.9.Аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь тухайн орон нутгийн харьяалалтай, байнгын оршин суугаа даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадална.

7.10.Хорт хавдар, сурьеэ, бөөрний дутагдал, эрхтэн шилжүүлэх мэс засал хийлгэсэн, эрхтний донор болсон, хүнд хэлбэрийн болон хавсарсан гэмтэл зэрэг өвчний улмаас эмчлүүлж, бусдын асрамжид байгаа, даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тухайн түр оршин суугчийн хаягаар магадлан шийдвэрлэж болно.

7.11.Энэ дүрмийн 7.8-д заасан хүндэтгэн үзэх шалтгааныг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 2.1.5-д зааснаар ойлгоно.

Найм.Аймаг, дүүргийн Засаг даргын чиг үүрэг

8.1.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлтэй холбогдсон үйл ажиллагаанд аймаг, дүүргийн Засаг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1.даатгуулагч, хүний эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэхтэй холбогдсон үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан ажиллаж, энэ чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

8.1.2.аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийг үйл ажиллагаа явуулах байраар хангаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн гишүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах талаар шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

8.1.3.эрүүл мэндийн байгууллагын менежерийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтэд хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч, хүнийг тогтмол хянах, эмчилгээний үр дүнг тооцох, орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх, аюулгүй хөдөлмөр эрхлэх мэдлэг, хандлага өөрчлөх үйл ажиллагааны асуудлыг тусгах, дүгнэхэд харгалзан үзэх;

8.1.4 Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн хамтарсан болон дахин магадлалын үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

8.2.Аймаг, дүүргийн Засаг дарга аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн тайланг жил бүр хэлэлцэж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэж ажиллана.

Ес.Эрүүл мэндийн байгууллагын чиг үүрэг

9.1.Эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн магадлалтай холбогдсон үйл ажиллагаанд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.Бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын төрөлжсөн мэргэшлийн эмч, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хяналтын эмч нь даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлыг энэ дүрмийн 4.12.1-д заасан хугацаанд багтаан Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх;

9.1.2.хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгох даатгуулагч, хүний тав тухтай үйлчлүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

9.1.3.сум, өрхийн болон төрөлжсөн мэргэшлийн эмч нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллан, гарсан зөрчлийг арилгуулах;

9.1.4.салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хурлыг зохион байгуулах, үйл ажиллагаа явуулахад шаардагдах байр, тоног төхөөрөмжөөр хангах, бусад шаардлагатай нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

9.1.5.тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, нөхцөлийг судлах, даатгуулагч, хүнийг хөдөлмөрийн чадвар алдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх судалгаа, шинжилгээний ажилд оролцох, дэмжих;

9.1.6.салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлтэй хамтран хяналт шалгалт хийх;

9.1.7.аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн магадлагч эмчийг эмчилгээ, оношилгооны удирдамжаар хангаж, холбогдох сургалтад хамруулах, шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх;

9.1.8.Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгосон иргэний эдгэрэлтийн байдалд хяналт тавих, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах асуудлыг эмчийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтэд тусгах, хяналт тавих;

9.1.9.Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах Магадлалын төв зөвлөлийн дахин болон хамтарсан магадлал, эрх бүхий байгууллагын хяналт шалгалт зохион байгуулах үед даатгуулагчид чирэгдэлгүй, дараалал харгалзахгүй оношилгоо, шинжилгээнд хамруулах, түргэн шуурхай үйлчлэх.

9.2.Даатгуулагч, хүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчийн эмчилгээ, үйлчилгээний зөвлөмж, зааврыг удаа дараа биелүүлээгүй, хяналтын үзлэг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдаагүй, тохиолдолд түүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг, бууруулах, цуцлах саналыг эрүүл мэндийн байгууллагаас салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлд гаргаж болно.

9.3.Салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хурлын шийдвэрээр хугацаагүйгээр хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон даатгуулагч, хүний эрүүл мэндийн байдалд харьяалах өрх болон сумын эмч хяналт тавьж ажиллана.

Арав. Цагийн хөлс олгох

10.1.Нийгмийн даатгалын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга)-ийн 43.3-т заасны дагуу цагийн хөлсийг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос баталсан хөдөлмөрийн хөлсний нэг цагийн доод хэмжээг дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар олгоно.

10.2.Энэ дүрмийн 12.3-т заасан хамтарсан магадлалын бүрэлдэхүүнд ажилласан Төв зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, төрөлжсөн мэргэшлийн эмч, мэргэжилтнүүдэд хуралд оролцсон цагаар нь тооцож, цагийн хөлс олгоно.

10.3.Аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь хөдөлмөрийн чадварыг сэргээн засах тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлж, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах чиглэлээр идэвх санаачилга гарган ажиллаж, гарч болзошгүй алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсэн аймаг, дүүргийн нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн, магадлагч эмч нарт шагнал, урамшуулал олгох тухай саналыг холбогдох байгууллагуудад уламжилж шийдвэрлүүлнэ.

10.4.Төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнд гурваас дээш жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан магадлагч эмч, Магадлалын төв зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргад хагас жил тутамд 1 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас олгоно.

10.5.Энэ дүрмийн 10.1-10.4-т заасан зардлыг харьяа нийгмийн даатгалын газрын төсөвт тусган хэрэгжүүлнэ.

Арван нэг. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн
мэдээллийн сан

11.1. Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь мэдээллийн нэгдсэн сантай байх ба уг сан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

- 11.1.1. төв зөвлөлийн;
- 11.1.2. салбар зөвлөлийн;
- 11.1.3. аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн.

11.2. Мэдээллийн нэгдсэн сан нь эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааг ил тод болгох, судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан, мэдээ гаргах, хяналт шалгалт хийх, төрийн байгууллага хооронд мэдээлэл харилцан солилцох, бусад цахим үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

11.3. Мэдээллийн нэгдсэн санд төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлөөс гаргасан шийдвэрийг төв, болон салбар, аймаг, дүүргийн зөвлөлийн нарийн бичгийн дарга бүртгэж, хөтөлнө.

11.4. Мэдээллийн нэгдсэн санд даатгуулагч, хүний доор дурдсан мэдээллийг тусгаж, даатгуулагч, хүний эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой мэдээллийг авах боломжтой байна:

11.4.1. овог нэр, регистрийн дугаар, нас, хүйс, хаяг, харьялал (аймаг, дүүрэг, сум, баг, хороо, тосгон), холбоо барих утасны дугаар, цахим шуудангийн хаяг, шаардлагатай үед холбоо барих хүний мэдээлэл;

11.4.2. хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгаан (онош)-ыг тогтоосон, сунгасан, цуцалсан, ажлын цаг богиносгосон, хөдөлмөрийн нөхцөл өөрчилсөн тухай бүх мэдээлэл;

11.4.3. хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоосон, сунгасан, цуцалсан, ажлын цаг богиносгосон, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх тухай шийдвэрийг гаргасан салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн гишүүдийн овог нэр, холбоо барих утасны дугаар;

11.4.4. хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх тухай шийдвэрийг салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлсэн хяналтын болон эмчлэгч эмчийн овог нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаар;

11.4.5. ёвчний түүх, амбулаторийн карт, оношилгоо, багажийн болон лабораторийн шинжилгээний дүгнэлт;

11.4.6. ажилласан байдал, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал, тусламж, үйлчилгээ, бусад зардал авсан мэдээлэл;

- 11.4.7.эмчилгээ, сувилгаа хийлгэсэн талаарх мэдээлэл;
- 11.4.8.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн байдал;
- 11.4.9.эмийн үнийн хөнгөлөлт авсан тухай мэдээлэл;
- 11.4.10.эрүүл мэндийн даатгалын мэдээлэл;
- 11.4.11.шаардлагатай бусад мэдээлэл.
- 11.5.Даатгуулагч, хүн мэдээллийн сангаас өөрийн хамаарал бүхий мэдээллийг авч болно.
- 11.6.салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн нарийн бичгийн дарга тухайн зөвлөлийн шийдвэр бүрийг цаг тухай бүрд мэдээллийн нэгдсэн санд оруулж, үнэн зөв байдлыг нь хариуцах бөгөөд бусад шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагаас авч тусгаж болно.
- 11.7.Энэ дүрмийн 11.4-т заасан мэдээллийн үнэн зөвийг салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцах ба 11.4 дэх хэсэгт заасан мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу төв болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөл хэрэгжүүлэн ажиллана.
- 11.8.Энэ дүрмийн 11.4.5-11.4.11-д заасан мэдээллийг холбогдох байгууллагаас Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд ирүүлнэ.
- 11.9Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай мэдээллийг Эрүүл мэндийн магадлалын төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь холбогдох байгууллагаас гаргуулан авах эрхтэй.

Арван хоёр. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн
үйл ажиллагааны хяналт шалгалт

12.1.Төв зөвлөл нь салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаа, цахим болон цаасан баримт бичиг, мэдээллийн санд хяналт тавьж ажиллана.

12.2.Төв зөвлөл мэдээллийн санг ашиглан үнэлгээ, дүгнэлт хийсний үндсэн дээр улсын дунджаас дээш эрсдэлтэй нөхцөл бүхий салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд жилд 3-аас доошгүй удаа дахин магадлал хийж шалгана.

12.3.Төв зөвлөл мэдээллийн санг ашиглан үнэлгээ, дүгнэлт хийсний үндсэн дээр өндөр эрсдэлтэй нөхцөл бүхий салбар болон аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд магадлалын төв зөвлөлийн шинжээч эмч болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөл болон холбогдох мэргэжлийн нийгэмлэг, холбоотой хамтарсан магадлалыг жилд 2-оос доошгүй удаа хийж шалгана.

12.4.Дахин болон хамтарсан магадлалд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг шинээр тогтоолгосон даатгуулагч, хүний 15-аас багагүй хувийг,

хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгуулсан даатгуулагч, хүний 10-аас багагүй хувийг хамруулна.

12.5.Төв зөвлөлийн хамтарсан болон дахин магадлалын үед даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг биеэр байлцуулан магадлах ба шаардлагатай тохиолдолд баримт бичгээр болон цахим хэлбэрээр шийдвэрлэж болно.

12.6.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төв болон салбар, аймаг, дүүргийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалт хийнэ.

12.7.Аймаг, дүүргийн магадлалын зөвлөл нь нийгмийн даатгал, нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн байгууллагын холбогдох цахим мэдээллийн санг ашиглан даатгуулагч, хүний эрүүл мэндтэй холбоотой шаардлагатай мэдээллийг авч хяналт тавина.

Арван гурав.Хариуцлага

13.1.Даатгуулагч, хүн хуурамч баримт бичиг бүрдүүлж, үйлдэж хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгохыг завдсан, тогтоолгосон, сунгуулсан бол төрд учирсан хохирлыг нийгмийн даатгалын санд нөхөн төлүүлж, холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.2.Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх асуудлаар иргэнээс хамааралгүйгээр магадлалын зөвлөлийн хуралд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв бүртгэж илгээгээгүй, хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлүүлэх хугацаа хэтэрч хуралд хэлэлцүүлснээс иргэнд учирсан тэтгэвэр, тэтгэмж болон бусад төлбөр, зардал, хөнгөлөлттэй холбоотой хохирлыг төрөлжсөн мэргэшлийн болон хяналтын эмч нь барагдуулж, хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.3.Төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмч, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нь хуурамч баримт бичиг бүрдүүлж, үйлдэж хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хугацаа, шалтгааныг даатгуулагч, хүнд тогтоолгохыг завдсан, тогтоолгосон, сунгуулсан бол холбогдох зөвлөлийн бүрэлдэхүүнээс хасаж, хохирлыг нийгмийн даатгал болон халамжийн санд нөхөн төлүүлж, холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.4.Хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хугацаа, шалтгааныг тогтоолгох, сунгуулах зорилгоор багажийн болон лабораторийн шинжилгээг хуурамчаар үйлдсэн эрүүл мэндийн байгууллагын ажилтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.5.Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг үндэслэлгүйгээр тогтоосон, сунгасан, шийдвэр гаргахад хууль бусаар бусдад нөлөөлсөн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн нарт холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэж, учруулсан хохирлыг нийгмийн даатгалын санд нөхөн төлүүлнэ.

13.6.Энэ дүрмийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Арван дөрөв. Бусад зүйл

14.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон хувь, хугацаанаас үл хамааран өөрийн өвчний байдал, үе шатад нөлөөлөхгүй ажил, хөдөлмөр эрхэлж болно.

14.2.Энэ дүрмийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой заавар, зөвлөмж, чиглэл гаргах, маягтыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж болно.

----о0о----